



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 45
Утас: 70049919, 70049973
www.miat.com

2024. 07. 03 № 01/1763

танай _____ -ны _____ №-г

Тодруулга хүргүүлэх тухай

МИАТ ТӨХК-ийн зарласан МИАТ/20240102090/03/01 дугаартай “Хөдөлмөр хамгааллын хувцас” Багц 1: Ажлын хувцасны тендертэй холбоотой гаргасан тодруулгын дагуу дараах тайлбарыг хүргүүлж байна.

Асуулт: 1.ТХ-Ө-02 загварын кодны материал ПЭ 80%-аас багагүй, Полиамид 70 аас ихгүй гэж заасан байгааг ПЭ 80%-аас багагүй эсвэл Полиамид 70-аас ихгүй гэж ойлгож болох уу? Тэгээд зөрүү 20-30% - ийг хөвөн буюу байгалийн ширхэгт байна гэсэн үг үү? Учир нь ПЭ 80%-аас багагүй, Полиамид 70-аас ихгүй байна гэсэн нийлбэр нь 150% болоод байгаа юм.

Хариулт: Хувцасны гадна материал: ПЭ 80 хувиас багагүй, Полиамид буюу капрон материал 20 хувиас ихгүй байна. Энэ талаар “Ажлын тусгай хувцас, толгой, хөл, хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага”-ийн 6.3.4-т зааж өгсөн бөгөөд Хүснэгт-9-ийг харна уу.

Асуулт: Загвар-2 техникийн бичиг баримт дээр Зуны ажлын хувцасны материал 300г/м2 байна гэж заасан боловч Ажлын тусгай хувцас, толгой хөл хамгаалах хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага бичиг баримтад 245-270 г/м2 байна гэж оруулсан байна. Ажлын хувцасны материалууд нь ихэвчлэн 220 - 240г/м2 байдаг. Эх загварыг бид 235г/м2 материалаар хийгээд, тендерт шалгарч гэрээ байгуулах үед зайлшгүй гэж үзвэл бид материалыг 245-270 эсвэл 300г/м2 - р захиалан хийлгэх боломжтой юм. Иймээс тодруулж өгнө үү.

Хариулт: Ажлын тусгай хувцас, толгой хөл хамгаалах хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага бичиг баримтад заасныг баримталах бөгөөд тус баримт бичгийн 14 дүгээр хүснэгтэд зааж өгснөөр ойлгоно. Тус хүснэгтэд Загвар-2 буюу ГҮАЕМХХН ажилтнуудын хувцас ТХ-3-02-ийг 245-270 гэж зааж өгсөн байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.МӨНХТАМИР

0100003410